




ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн  
23/05 тоот тушаалын 05 дугаар хавсралт



**ТРАСТ ФИНАНС БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН  
ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО**

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно



ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн  
23/05 тоот тушаалын 05 дугаар хавсралт


<i>Хамрах хүрээ:</i> Трастфинанс ББСБ	<i>Хариуцах эзэн:</i> ТРАСТФИНАНС ББСБ ХХК нэр дэвшүүлэх хороо
<i>Хувийг хадгалах:</i> Гүйцэтгэх захирал	<i>Танилцах:</i> ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын баг
<i>Хүчинтэй хугацаа:</i> 2023.10.10	<i>Хуудасны тоо:</i> 4

**Өөрчлөлтийн түүх:**

№	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1			
2			
3			
4			
5			
6			
7			



ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн  
23/05 тоот тушаалын 05 дугаар хавсралт



## БОДЛОГЫН ТОВЬЁОГ

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**ГУРАВ. БУСАД**



## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү баримт бичгээр компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халааны бодлогыг тодорхойлно.
- 1.2 Бодлогын баримт бичгийн зорилго нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд эрх бүхий албан тушаалтны залгамж халааг тодорхойлоход оршино.
- 1.3 Эрх бүхий албан тушаалтан гэдэгт дараах албан тушаалтнуудыг ойлгоно. Үүнд:
  - 1.3.1 ТУЗ-н дарга, гишүүд
  - 1.3.2 ТУЗ-н нарийн бичгийн дарга
  - 1.3.3 Гүйцэтгэх захирал
  - 1.3.4 Зээлийн хорооны гишүүд
- 1.4 ББСБ нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог байгуулах замаар Бодлогыг хэрэгжүүлнэ.

## ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1 ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /цаашид "Хороо" гэх/ нь залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж ТУЗ-д танилцуулна.
- 2.2 Хороо нь эрх бүхий албан тушаалд дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.3 Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно. Хороо нь компанийн хүний нөөц болон гаднаас эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгоно.
- 2.4 Хорооноос эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргана.
- 2.5 Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон гүйцэтгэх удирдлага нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.

## ГУРАВ. БУСАД

- 3.1 Энэ баримт бичгийн хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, хэрэгжихүйц байлгах, сайжруулах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг эдэлнэ.